

байна. Хэргийг шуухээр авч хэлэлцсэний дараа уг эд юмсыг хулээн авсан Хэлэлиэн Тохирогч Зтгээд туунийг эзэмших эрх бүхий иргэнд шилжуулэн өгөх зорилгоор Хэлэлиэн Тохирогч нөгөө Этгээддээ өгнө. Хэрэв шаардлага явуулж байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээдийн нутаг дэвсгэрт дээрх эд шсшг эзэмших эрх бүхий иргэн байвал Хэлэлцэн Тохирогч тэр Этгээд шаардлага хулээн авч байгаа. Хэлэлиэн Тохирогч нөгөө Этгээдийнхээ зөвшөөрснөөр уг, иргэнд эд юмсыг шууд шилжуулэн өгөх эрхтэй.

Ерэн нэгдүгээр зүйл

Хэрэгтнийг дамжуулан өнгөрүүлэх

1. Гурав дахь улсаао Хэлэлцэн Тохирогч аль нэг Этгээдэд шилжуулэн өгөх хэрэгтнийг өөрийн нутаг дэвсгэр дээгуур дамжуулан өнгөрүүлэхийг. Хэлэлцэн Тохирогч хоёр Зтгээд бие биедээ зөвшөөрнө. Шаардлага хулээн авч байгаа Хэлэлиэн Тохирогч Зтгээд энэхуу Гэрээгээр шилжуулэн өгөхийг заагагуй тохиолдолд дээр дурдсан хэрэгтнийг дамжуулан өгөхийг зөвшөөрөх уурэгтуй болно.

2. Дамжуулан өнгөрүүлэх шаардлагыг шилжуулэн өгөх тухай шаардлагын нэг адил уйлдэж гуйцэтгэнэ.

3. Шаардлага хулээн авч байгаа Хэлэлиэн Тохирогч Зтгээд ямар хэлбэрээр дамжуулан өнгөрүүлэхээ өөрөө шийдвэрлэнэ.

Ерэн хоёрдугаар зүйл

Дамжуулан өнгөрүүлэх болон шилжуулэн өгөхтэй холбогдсон зардал

Дамжуулан өнгөрүүлэх болон шилжуулэн өгөхтэй холбогдсон зардлыг нутаг дэвсгэр дээр нь уг хэрэг гарсан Хэлэлцэн Тохирогч Зтгээд гаргана.